



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-13

1.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай, Харилцаа холбооны ухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг

5-9

2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

9-12

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 03 дугаар сарын 15-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 25 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Л.Мөнхбаатар;

Чөлөөтэй: Ш.Адъяаа, Н.Алтанхуяг, Д.Ганбат, Б.Пүрэвдорж, Б.Энх-Амгалан;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнх-Оргил;

Тасалсан: Ш.Раднаасэд.

Нэг.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, мөн газрын Хуулийн бодлогын газрын дарга О.Машбат, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хуулийн бодлогын зөвлөх А.Бямбажаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийн талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир үг хэлэв.

Б.Энхбаяр: Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд

өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Энхбаяр тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Энхбаяр, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс үг хэлээгүй болно.

Б.Энхбаяр: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11

72.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 26 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 13 цаг 51 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Үндсэн
хууль” танхим 13 цаг 25 минут.

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Энхбаяр: Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул энэ хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Эхлээд ирцийг танилцуулъя.

Энхбаяр ирсэн байна, Бат-Амгалан ирсэн байна, Бямбацогт ирсэн байна, Дэлгэрсайхан ирсэн байна, Ц.Мөнхцэцэг ирсэн байна, Нямбаатар ирсэн байна, Сандаг-Очир ирсэн байна, Сүхбаатар ирсэн байна, Сэргэлэн ирсэн байна, Учрал ирсэн байна.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт олон нийтийн сүлжээнд Хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг.

2. Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Эхний асуудал олон нийтийн сүлжээнд Хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Содбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Бямбажаргал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Машбат нар оролцож байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Содбаатар дарга танилцуулна.

2 номерын микрофон.

Я.Содбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулиудыг 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталж Улсын Их Хурлын дарга 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 16 цаг 50 минутад ёсчлон

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын ЕНБД-ын 2023 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 0126 дугаар албан тоотгоор ирүүлсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын үндсэн хуулийн 33 дугаар дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг тус тус үндэслэн Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулиудад дараах үндэслэлээр бүхэлд нь хориг тавьж байна.

Нэг. Монгол Улсын Засгийн газар 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлсэн бөгөөд Монгол Улсын Их Хурал уг хуулийн төслийг хэлэлцэж эхэлснээс хойш 2 өдөрт багтаан эцэслэн баталжээ.

Хуулийн төслийг боловсруулах хэлэлцэн батлах үйл явцад иргэн олон нийтийн оролцоог хангаагүй, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээд төрийн болон ТББ, мэргэжлийн болон судалгааны байгууллагуудаар хэлэлцүүлж саналыг аваагүй нь Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт иргэд бусад байгууллага хуулийн төслийн тухай хуулийн саналаа хууль санаачлагчдад уламжилна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 8.1.6 дахь заалт 38 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.

Энэ нь Монгол Улсын үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн ардчилсан ёс, үндэсний эв нэгдлийг хангах,

хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн хэмээх заалтыг зөрчих нөхцөлийг бий болгосон байна аа.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, Хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна хэмээн заасан.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт хүний эрх эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй хэмээн Үндсэн хуулиар хязгаарлалт тогтоосныг анхаарч байх ёстой.

Тиймээс хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа хууль, тогтоомжийг боловсруулах хэлэлцэн батлахдаа олон нийтийн санаа оролцоог сайтар хангаж, мэргэжлийн болон судалгааны байгууллагын санаа бодлыг сонсож, олон улсын сайн туршилага судалгаа шинжилгээнд суурилан Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчмыг чанд баримталж байх учиртай.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-т Улсын Их Хурлын баталсан хууль бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих хэмээн Монгол Улсын Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхэд заасан байдаг.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэгт энэ хуулийн 45.4-т заасны дагуу илгээсэн хууль тогтоолыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хүлээж авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Монгол Улсын Ерөнхийлөгч тухайн хууль тогтоолыг бүхэлд нь буюу

тухайн зарим хэсэгт нь хориг тавих эсэх асуудлыг шийдвэрлэнэ гэж заасан.

Олон нийтийн сүлжээнд хүний эрх хамгаалах тухай болон түүнийг дагалдан батлагдсан нэр бүхий хуулиудыг дагаж мөрдөх хугацааг 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр байхаар хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох хэсгүүдийг зөрчиж Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг тавих эрхийг хязгаарласан байна.

Иймд энэхүү хууль тогтоомжид заасан үндэслэлүүдээр Монгол Улсын Ерөнхийлөгч дээрх хуулиудад бүхэлд нь хориг тавьж байна. Монгол Улсын Ерөнхийлөгч цахим орчин олон нийтийн сүлжээний талаар эрх зүйн орчныг тодорхой боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байгааг бас энд тэмдэглэн хэлье.

Гэхдээ энэ хууль нь төдийгүй ер нь хууль тогтоомжуудыг парламент батлан гаргахдаа эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдүүдийн оролцоог хангах, эрдэмтэн судлаачид, мэргэжлийн холбоод, хүмүүсийн саналыг авч сайтар хэлэлцэн хийгүй чамбай хууль гаргаж байх нь нэн чухал юм.

Олон нийтийн саналыг тусгаж, олон нийтээр хэлэлцүүлж, асуудалд тооцоо судалгаатай, шинжлэх ухаанч байр сууриас хандаж олон улсын сайн туршлага сайн жишиг стандартыг бүх талаас судлан өөрийн орны давуу тал, онцлогийг тусгаж гаргаж байх шаардлагатай гэж үзэж байгааг ч энд онцлон тэмдэглэе.

Ингээд Монгол Улсын Ерөнхийлөгчийн дээрх хуулиудад тавьсан хоригийг хууль тогтоомжийн дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсэж байна.

Б.Энхбаяр: Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригтой холбогдуулан

асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү? Алга байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригтой холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү?

Сандаг-Очир гишүүнээр тасаллаа.

Сандаг-Очир гишүүн үгээ хэлье.

Ц.Сандаг-Очир: Бүгдээрэнд нь өдрийн мэнд хүргэе.

Ерөнхийлөгчийн хоригийг бас ойлгож байгаа. Ерөнхийдөө хуулийг яаралтай горимоор хэлэлцэж баталсан. Ер нь одоо хуулийг хэлэлцэхдээ иргэд олон нийтийн санаа бодлыг тусгаагүй, олон нийтээр хэлэлцүүлээгүй, эрх ашиг нь хөндөгдөж байгаа иргэд ТББ иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангаагүй гэдгээр л хууль тогтоомжийн хуулийг зөрчсөн байна л гэж үзэж байгаа юм.

Тэрнээс яг одоо энэ олон нийтийн сүлжээнд дэх Хүний эрхийн тухай хууль бол нийгэмд одоо зайлиггүй байх ёстой юу гэвэл байх ёстой байна. Хууль зүйн болоод одоо практик хэрэгцээ шаардлага бол зайлиггүй байна.

Сая энэ хууль батлагдсантай холбогдуулж бас орон нутагт иргэдтэйгээ уулзаж энэ хуулийн чиглэлээр мэдээлэл танилцуулга хийхэд бол энэ хуулийг эсэргүүцэж байгаа иргэд бол ерөөсөө байхгүй байна. Зайлиггүй байх ёстой хууль юм байна. Өнөөдөр энэ цахим гэмт хэргээс үүдэлтэйгээр түүний хохирогч болж байгаа олон 10 кэйс, олон 10 тохиолдлууд байна.

Тийм учраас энэ хууль бол одоо нэг талаар бол байх ёстой хуулийн нэг байна шүү л гэж ингэж одоо Их Хурлын гишүүд бид нарт бол хэлж байсан. Гагцхүү Ерөнхийлөгчийн зүгээс бол энэ эрх ашиг нь хөндөгдөж байгаа олон нийтийн оролцоог хангаагүй цагт баригдаж хэт яаралтай

горимоор хэлэлцэж ингэж баталсан байгаа л гэж би хувьдаа бол ойлгож байгаа юм.

Тэгэхээр одоо цаашидаа бол Цахим хөгжлийн яам энэ одоо хууль зөрчсөн гээд энэ хууль тогтоомжийн хүрээнд энэ хуулийг хэлэлцэх тэр процедурын алдаа гаргалгүйгээр олон нийтээр хэлэлцүүлээд санал хүсэлтийг нь сонсоод иргэний нийгмийн байгууллагууд одоо эрдэмтэн судлаачдын саналыг сонсоод ахиж оруулж ирнэ байх гэж би бол хувьдаа бодож байгаа. Тэгэхгүй бол үнэхээр энэ нийгэмд бол одоо цахим гэмт хэргээс үүдэлтэйгээр цахим мөрийтэй тоглоом, цахим гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийлэл гээд олон арван гэмт хэргийн хохирогч бол өдрөөс өдөрт, сар болгонд одоо хохирлын хэмжээ гэмт хэргийн гаралт бол нэмэгдэж байгааг та бид бол статистик тоо баримтаас харж байгаа.

Тийм учраас би бол одоо энийг одоо Учрал гишүүний хууль гээд тогтчихсон юм байна лээ ард иргэдийн дотор. Учралын хууль энэ тэр гээд. Тэгэхээр Учрал гишүүн бол энэ хуулиа бол яаралтай горимоор энэ процедурынх нь дагуу ингэж ахиж өргөн барьж оруулж ирнэ байх гэж ингэж бодож байна.

Баярлалаа.

Б.Энхбаяр: Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригтой холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна.

Та бүхэнд Дэгийн хуулийн тайлбарыг уншиж өгье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 88.5-д гишүүд энэ хуулийн 88.4-т заасны дагуу үг хэлсний дараа Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах эсэх асуудлаар ил санал хураалт явуулах бөгөөд хэрэв хууль тогтоолын зарим

хэсэгт хориг тавьсан бол тухайн зүйл заалт нэг бүрээр санал хураалт явуулж дүнг танилцуулна гэж заасан байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 88.6-д Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3 буюу 66.6 хувь нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж аваагүй бол хууль тогтоол хүчин төгөлдөр үлдэнэ гэж заасан байна.

Одоо санал хураалт явуулна.

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр баталсан Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Мөнхцэцэг гишүүн микрофонд хэлчих. Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Сая санал хураалтын төхөөрөмж маань гацсан учраас би энэ дээр хоцроод. Мөнхцэцэг гишүүнийг дэмжсэн саналд тооцож оруулъя. 100 хувийн саналаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй гэж үзлээ.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай

хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Хүний эрхийн дэд хорооны дарга Мөнхцэцэг танилцуулна.

Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү. Алга байна.

Нямбаатар сайд, Цогтбаатар гишүүн байна уу? Цогтбаатар гишүүнээр тасаллаа.

Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Баярлалаа гишүүдэд.

Хаврын чуулганы нээлтийн өдрийн мэндийг хүргэе. Энэ хаврын чуулган бол маш их хариуцлагатай бөгөөд нийгэм, эдийн засгийн олон тулгамдсан асуудлыг шийдвэрлэх ийм бидний хувьд их цаг алдаж болохгүй, ихийг амжуулах ёстой чуулган байгаа юм. Тэгэхээр хууль зүй, дотоод хэргийн яамнаас одоо өргөн барьчхаад байгаа хорь гаран төсөл байгаа. Тэгээд Хууль зүйн байнгын хорооны даргад би ямар санал хэлэх гэж байна вэ гэвэл манай Байнгын хорооны бас

нэлээд гишүүд нь Засгийн газрын гишүүд болсон учраас нөгөө өмнө нь ахалж байсан ажлын хэсгүүдийнх нь хуулийг өөрсдөөр нь дуусгуулах ажлыг нэгдүгээрт хариуцаж өгөөч.

Та ч гэсэн бас хэд хэдэн хуулиуд ахалж байгаа.

Хоёрдугаарт бид нар энэ хаврын чуулганы өнгө аясын талаар сая бас Улсын Их Хурлын дарга нээлтийн чуулганы хуралдаан дээр ч хэллээ. Авлига албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулиудыг тэргүүн ээлжинд шийдье ээ гээд.

Тэгэхээр би бол цаг алдалгүй хэдүүлээ ирэх 7 хоногт нөгөө Урт нэртэй хууль буюу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах урьдчилан сэргийлэх тухай хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцээд явъя гэсэн ийм саналыг хэлж байгаа.

Дээр нь манай Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр боловсруулагдсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2 процессын хууль энд ирчихсэн байгаа.

Нэг нь хэлэлцэх эсэх нь дэмжигдээгүй эрүүгийн процессыг бид нар нэмж өргөн барина. Энийг багцлаад өмнө нь хэлэлцэх эсэхээ шийдсэн хуулиудын ажлын хэсгийг гаргаад вакумжаад жоохон ажлаа урагшлуулбал яасан юм бэ гэдэг ийм санаачилгыг гаргаж байна.

Эцэс сүүлд нь бид нар энэ 3 дугаар сарын сүүл 4 дүгээр сардаа багтаж Монгол Улсад Шүүх байгуулах тухай хуулийн том төслийг өргөн барина.

Энэ шүүхийн тухай хуулийн шинэчлэлийн нэг салиггүй нэг хэсэг байдаг. Тэгээд бид нар одоо ШЕЗ-ийг хараад 2

жил хүлээсэн. ШЕЗ-өөс тодорхой саналууд ирсэн. Хуульд ШЕЗ-ийн саналыг харгалзаж Засгийн газар шүүх байгуулах хуулийг өргөн барьдаг. ШЕЗ-тэй ойлголцсоны дараа мэргэжлийн байнгын хороо Хууль зүйн байнгын хорооныхоо гишүүдтэй бас бид нэлээд ойлголцох ажлуудыг төсөл дээрээ ярьж байгаад өргөн барья гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа.

Өнөөдрийн энэ юунд ороогүй бид нарын хуваарь хуанлийн хуваарьт ороогүй бас нэг том бүлэг асуудал бол хувийн эрх зүйн шинэчлэлийн том хууль тогтоомжуудыг өргөн барихаар боловсруулах ажил нэлээн явагдаж байгаа.

Арилжааны тухай хууль, Хэрэглэгчийн гэрээний тухай хууль, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэсэн ийм төслүүд бас энэ хуанлид ороогүй ч гэсэн энэ хаврын чуулганаар өргөн барихаар төлөвлөж байгаа шүү гэдгийг бас Байнгын хорооныхоо гишүүдэд хэлье.

Тэгэхээр байнгын хорооны дарга нөгөө өмнө нь байгаа явж ирсэн ажлын хэсгүүдээ жоохон шахаад зарим дарга нарыг нь солихоор бол солиод одоо Дэлгэрсайхан гишүүн, Сандаг-Очир гишүүн, Бат-Амгалан гишүүн, Цогтбаатар гишүүн, Сэргэлэн гишүүн энэ тэрээр ингээд ахлуулаад явбал яасан юм бэ? Ажлыг нь жоохон шахаад өгвөл яасан юм бэ гэж хэлэх гэсэн юм.

Б.Энхбаяр: Энэ бол 2023 оны хаврын ээлжит чуулганы 3 сарын буюу одоо 3 сар гэдэг маань үндсэндээ 2 долоо хоногийн хуралдааны Байнгын хорооны хэлэлцэх асуудал байгаа.

Үндсэндээ энэ 7 хоног маань ингээд маргааш нөгөөдөр гээд чуулган явчихна. Тэгэхээр үндсэндээ ирэх 7 хоногийн л гэсэн үг. Тэгэхээр ирэх 7 хоногт бол бид Нийтийн ашиг сонирхлын ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх энэ хуулийн

нэмэлт, өөрчлөлтийн төсөл мөн Хууль, тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл гэсэн энэ 2 төслийг бол Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцье.

Сая Нямбаатар сайд танилцуулж байгаа. Сая үдээс өмнө Улсын Их Хурлын дарга ч гэсэн хэлсэн.

Энэ удаагийн хаврын чуулган бол одоо авлигын эсрэг авлигатай тэмцэх парламентын манлайллыг үзүүлсэн чуулган байх учиртай. Тэр дотроо одоо энэ асуудлаар бол мэргэжлийн Хууль зүйн байнгын хорооны үүрэх ачаалал хариуцаж байгаа эрхлэх асуудал бол одоо нэн их байгааг тэмдэглэж хэлсэн.

Тийм учраас Засгийн газартайгаа тэр дундаа Хууль зүй, дотоод хэргийн сайд Нямбаатар сайд сая хэлж танилцуулсан. Энэ одоо бодлогын олон хууль тогтоомжийг Улсын Их Хурлын түвшинд хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх хэлэлцүүлэх шатанд манай Байнгын хорооны бүх гишүүд улс төрийн одоо манлайлал үзүүлж ажиллах учиртайг бол тэмдэглэж байна. Тэгээд саяын ярьсан тэр ажлын хэсгүүдийг бол бас тодотгоод шуурхай хэлэлцээд явна гэсэн ийм хариултыг өгье.

Цогтбаатар гишүүн асуулт асууя.

П.Цогтбаатар: Баярлалаа. Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Зүгээр надад нэг ийм асуулт байна. Байнгын хороон дарга аа. Хүний эрхийн дэд хороон дээр чуулган завсарлахаас өмнө юу тавьсан байгаа. Энэ утааны асуудлаар сонсгол хийе ээ гэдэг саналыг гаргаад манай Их Хурлын бас нэлээн олон гишүүн дэмжээд ингээд өргөн барьчихсан байж байгаа.

Тэгэхээр Хүний эрхийн дэд хороон дээр энэ утааны асуудлаарх Улаанбаатар хотод хотын утааны асуудлаарх тэгээд энэ түлшний асуудлаар сонсголыг 4 сардаа багтаад болбол 4 сарын эхний

одоо хагастаа багтаад хиймээр байгаа юм. Энийг та бас одоо Хүний эрхийн дэд хороо Хууль зүйн байнгын хороондоо харьяалагдаж явдаг учраас удирдлагууд маань та нар хоорондоо ярьж байгаад энийг нэг зохицуулж өгөөч ээ гэж хэлмээр байна.

Тэгэхгүй бол одоо нөгөө цаг дулаарчихлаар бид нар чинь ингээд тайвширчихна шүү дээ. Гэтэл дараагийн өвөл болоход одоо бэлтгэл одоо ингээд тасрахгүй хийгдээд явж байх ёстой. Тэгэхээр алдаа, дутагдал юу юун дээр анхаарах ёстой байсан юм. Энэ бүгдийгээ одоо бид нар ярьж байх ёстой. Бид нарт бол ингээд Их Хурал дээр асуудал байгаагаа мэдээд байгаа боловч хаанаас ургаж гарч ирчхээд энэ асуудал чинь яваад байна. Хуучин алга болчихсон байсан юм одоо яагаад буцаад гараад ирэв ээ. Энэ юунд асуудал нь байна вэ гэдгээ бид сонсохгүй бол бас болмооргүй юм шиг байгаад байгаа юм.

Баярлалаа.

Б.Энхбаяр: Нийслэл Улаанбаатар хотын утаа бас ярьж байгаа. Тэгэхээр Улаанбаатар хотын асуудал хариуцсан сайд Сүхбаатар ямар байр суурьтай байна вэ?

Ж.Сүхбаатар: Үгүй ээ яах вэ нөгөө утаа, түгжрэл ч одоо шууд холбоо бол бас ярихад бол төвөгтэй. Гэхдээ холбоо бол байгаа. Утаа гэдэг бол бас авлигын утаа гэж байна, ядуурлын утаа гэж байна, түгжрэлээс одоо үүдэж байгаа утаа. Тэгэхээр би энэ хэний Цогтбаатар гишүүний хэлээд байгаа яагаад бас зөв вэ гэхээр саяхан би чинь бас нөгөө түгжрэлтэй холбоотой юм яадаг учраас заримдаа бас таксигаар бас явна л даа. Тэгээд таксины жолоочтой ярьж байхад бол нэг зүйл хэлж байгаа юм. Сүүлийн үед хүмүүс бас ингээд утаа энэ жил бол тэр шахмал түвшинээс бас заримдаа бүгд болоогүй ээ. Энэ суудлын машинуудын сүүлд орж ирсэн энэ хуучин машинуудын шүүлтүүрийг одоо ингээд их хэмжээгээр

гаргаад ингээд шүүлтүүргүй байгаад байгаа.

Тэгэхээр энэ бол автомашинуудын одоо хаяж байгаа бас тортог утаа их өндөр байгаа шүү. Энийг та нар нэг тусад нь одоо та цаашаагаа хэлж энэ хүмүүс яриад байгаа юм. Та нар энийг тодруулаарай гээд байгаа юм.

Тэгэхээр тэр утгаараа ингээд иргэдийн ойлголтыг жигдлэх үүднээсээ манай Засгийн газар дээр бол Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо ажиллаж байгаа. Тэгээд ер нь бол нэг Их Хурлын түвшиндээ одоо ярилцах нь бол иргэдэд мэдээлэл өгөх ач холбогдолтой учраас би Хүний эрхийн дэд хорооныхоо хувьд саяын энэ өвөл одоо юу болчхов гэдэг асуудал дээр би энэ Цогтоо гишүүний энэ яриад байгааг бол тодруулах нь зүйтэй гэж үзэж байгаа юм.

Ер нь бид чиний өвлийг мартах биш одоо энэ өвлийг дуусгаад дараачийн өвөлдөө гэхэд дараачийн өвлийн утаа түгжрэлтэй бид дахиад л ярьдаг юмаа ярих биш яг одоо эндээ энийгээ дүгнээд яриад бэлтгэлтэй орчихсон байхыг дэмжиж байна.

Одоо ч гэсэн бид нарын манай Үндэсний хороо хүртэл одоо энэ түгжрэл төвлөрөл дээр асуудал дээр хамгийн идэвхтэй одоо ажиллаж эхэлж байгаа шүү дээ. Яагаад гэвэл дараа жилийн өвөл их ойрхон байгаа байхгүй юу. Одоо ингээд л өвөл эхэлнэ. Тэгэхээр энэ утгаараа бол би энэ асуудлыг нь одоо Хүний эрхийн дэд хороон дээрээ яриад энэ нийгэм бас мэдээлэл хүлээгээд байгаа юм байна лээ.

Б.Энхбаяр: Цогтбаатар гишүүний санаачилгыг бол бүрэн дэмжиж байгаа.

Тэгэхээр 4 сар гарангуут Хүний эрхийн дэд хороог хуралдуулж энэ Улаанбаатар хотын утаатай холбоотой асуудлаар нээлттэй сонсгол явуулах санаачилгыг бас даргын зөвлөлийн хурал дээр санал тавьж, Мөнхцэцэг даргатай

ярьж байгаа өдрөө товльё. Энэ чинь нөгөө бэлтгэл ажил бас байх ёстой шүү дээ. Ялангуяа нөгөө иргэд олон нийтэд мэдээлэл өгөх гэж байгаа учраас бэлтгэл ажлуудаа бас хангах учиртай.

Тэгээд хугацааг нь бол Мөнхцэцэг даргатай ярьж байгаад зохион байгуулъя гэсэн ийм хариултыг өгье.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Алга байна. Санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*